



- Тухайн бараанд хийх шинжилгээ нь итгэмжлэлийн хүрээний тодорхойлолтод тусгагдаагүй

- Нэмэлт болон давтан шинжилгээ хийх

- Чанарын гарын авлагад заасны дагуу гадаад хяналтанд тухайн дээжийг хамруулах

#### **8. Шинжилгээний төлбөр хэд байдаг вэ?**

ГТЛ-ийн шинжилгээнд хамрагдах барааны төлбөр ГЕГ-ын даргын 2013 оны 199 дүгээр тушаалын 2-р хавсралтаар баталсан байдаг.

#### **9. Дээжийг хэдэн цаг хүртэл хүлээн авдаг вэ?**

Ажлын өдөр 08.30-17.00 цаг хүртэл хүлээн авна.

Танд лавлах зүйл байна уу!



**1800-1281**

Гааль сонсож байна



Талархал



Гомдол



Асуулг



Санал

#### **ГААЛИЙН ЛАВЛАХ УТАС**

Гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар үйлчлүүлэгч иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын санал, хүсэлт, гомдол, мэдээллийг хүлээн авах, гаалийн хууль тогтоомж, заавар, журам, гаалийн үйлчилгээний талаар мэдээ, мэдээллээр хангах, сан бүрдүүлэх зорилгоор “Гаалийн лавлах-1281” нээлттэй утас ажиллуулж байна.

Гаалийн байгууллагын үйл ажиллагааны талаархи иргэд, байгууллагын асуултуудыг нэгтгэн, дүн шинжилгээ хийж, дүгнэлт гарган мэдээлэл, гомдол саналын мөрөөр шаардлагатай арга хэмжээ авах, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллаж, мэдээлэл, зөвлөлгөө өгөх, сурталчилгаа хийх болон гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.



МОНГОЛ УЛСЫН  
ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

## **ГААЛИЙН ТӨВ ЛАБОРАТОРИ**



Хаяг:  
Сүхбаатар дүүрэг, "Их тойруу-81/1",  
Улаанбаатар-14193, Монгол Улс  
Утас: (976-11) - 350049  
Факс: (976-11) - 350048  
E-mail: info@customs.mn  
Интернет: <http://www.customs.gov.mn>

УЛААНБААТАР ХОТ  
2019 ОН



## ГЕГ-ын дэргэдэх Гаалийн Төв Лаборатори

### ГААЛИЙН ТӨВ ЛАБОРАТОРИ

Гаалийн төв лаборатори нь “Гаалийн тухай хууль”-д заасны дагуу гаалийн хилээр нэвтрүүлэх бараа тээврийн хэрэгсэл болон тэдгээртэй холбоотой бичиг баримтад гаалийн хяналт хийх явцад мэргэжлийн тусгай мэдлэг зайлшгүй шаардагдах, гаалийн зорилгоор барааны ангиллын кодыг тодорхойлох тохиолдолд магадлан шинжилгээг хийх, мансууруулах, сэтгэц нөлөөт бодисыг таньж илрүүлэх зорилго бүхий гаалийн хяналт, шалгалтын явцад гарсан маргаантай асуудлыг шийдвэрлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг гаалийн хяналтын байгууллагын нэг юм.

#### 1. Магадлан шинжилгээг хийх эрх зүйн бичиг баримтууд

1) Гаалийн тухай хууль

2) ГЕГ-ын 2008 оны №683 дугаар “Магадлан шинжилгээ хийх, дүгнэлт гаргах журам”

3) ГЕГ-ын даргын 08 сарын 18-ны өдрийн №А/201 “Гаалийн бүрдүүлэлт хийж, улсын хилээр нэвтрүүлж байх барааны кодлосон жагсаалт” тушаал

#### 2. Гаалийн төв лабораторийн шинжилгээнд ямар нөхцөлд хамрагддаг вэ?

1) Гаалийн хилээр нэвтрүүлэх бараанд гаалийн зорилгоор барааны ангиллын кодыг тодорхойлох тохиолдолд

2) ААН-ийн албан хүсэлтээр барааны ангиллын кодыг урьдчилан тодорхойлуулах зорилгоор

3) №А/201 “Гаалийн бүрдүүлэлт хийж, улсын хилээр нэвтрүүлж байх барааны кодлосон жагсаалт”-д хамрагдсан бараанд

#### 3. ГТЛ-ийн шинжилгээнд хамруулахад ямар ямар бичиг баримт бүрдүүлэх вэ?

- Үнийн нэхэмжлэх

- Сав баглаа боодлын тодорхойлолт

- Бараа худалдах, худалдан авах тухай гэрээ

- Тухайн бодис үйлдвэрлэгчийн чанарын гэрчилгээ, аюулгүй ажиллагааны заавар

- ААН-ийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар

- Эрх бүхий байгууллагын зөвшөөрөл /БОНХЯ, ҮХААЯ, ЭМЯ, АМГТХЭГ-г.м/ шаардлагатай тохиолдолд

#### 4. Лабораторийн шинжилгээнд хамруулах дээжний хэмжээ

“Магадлан шинжилгээ хийх, дүгнэлт гаргах журам”-ын 3.2-д Гаалийн улсын байцаагч нь гаалийн хяналтанд байгаа бараанаас сорьц, дээж, загвар авахдаа мэдүүлэгчийг байлцуулан шинжилгээнд тухайн барааг бүрэн төлөөлөх хүрэлцэхүйц стандартад заасан хамгийн бага хэмжээтэй дээжийг авна.

**Химийн бодисын дээж:** шингэн – 200 мл-ээс багагүй, хуурай - 200 гр-аас багагүй

**Согтууруулах ундааны дээж** 1.5 л-ээс багагүй, шар айраг 3 л -ээс багагүй

**Нефтийн бүтээгдэхүүний дээж** 1,5л-ээс багагүй

**Эрдэс түүхий эд:** Хүдэр, баяжмалынын дээж- 5.0кг-аас багагүй, Нүүрс-5.0кг-аас багагүй,

#### Ноос, ноолуурын ширхэгт материалын дээж

- боловсруулсан /самнасан ноос, ноолуур/-150 гр,

- анхан шатны боловсруулалт хийгдсэн хонины ноос /угаасан/-1500 гр,

- анхан шатны боловсруулалт хийгдсэн тэмээний ноос /угаасан/-900 гр,

- бусад ширхэгт материал-600 гр-аас багагүй

- утас, ээрмэл: дээжний төрөл /парт/ тус бүрээс 1 дамар

- нэхмэл даавуу: өргөн энгээрээ урт нь 1 м-ээс багагүй

#### 5. Лабораторид дээжийг хамруулах дэс дараалал

- Гаалийн байгууллагад барааг мэдүүлнэ

- Мэдүүлсэн бараанаас ГУБ дээж авч, битүүмжлэн, CAIS програмд бүртгэж ГТЛ-д хүргүүлнэ

- ГЛ нь дээжийг магадлан шинжилж, дүгнэлтийг цахим хэлбэрээр гаалийн газар хороонд илгээнэ

#### 6. Шинжилгээг ямар хугацаанд хийж гүйцэтгэх вэ?

**Магадлан шинжилгээ хийх хугацааг Гаалийн тухай хуулийн 252.6-д заасан хугацаанд хийж гүйцэтгэнэ. /Идээжинд/**

- Химийн бодисын дээж: ажлын 1-3 хүртэл хоногт

- Согтууруулах ундааны дээж: ажлын 1-3 хоног

- Нефтийн бүтээгдэхүүний дээж: ажлын 1-3 хоног

- Хүдэр, баяжмал, нүүрсний дээж: ажлын 3-5 хоног

- Ноос, ноолуурын дээж: ажлын 2-3 хоног

- Мод модон бүтээгдэхүүн: 2-5 хоног

- Түүх соёлын дурсгалт зүйлс: 3-15 хоног

#### 7. Шинжилгээний төлбөрийг хэрхэн хийх вэ?

Шинжилгээ бүрэн хийгдэж дууссаны дараа шинжилгээний төлбөрийг CAIS программ дээр үүссэн нэхэмжлэлийн хатуу дугаарын дагуу мэдүүлэгч төлбөрийг банкинд тушаана.

#### 8. Ямар тохиолдолд гадны байгууллагаар шинжлүүлдэг вэ?